

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

### Гэрээний загвар батлах тухай

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.2 дах заалт, 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтуудыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь**:

1. Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчийн дамжуулагчтай байгуулах “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай гэрээний загвар”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан гэрээний загварыг мөрдөж ажиллахыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК /Ж.Равдандорж/, Сэргээгдэх эрчим хүчний барилга, байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.

ДАРГА

С.ОТГОНБАЯР

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Р.МЯГМАР

ЗОХИЦУУЛАГЧ

Т.ГАНТӨМӨР

**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ**

**ТӨРИЙН ӨМЧИТ ХК**

болон

“\_\_\_\_\_” ХХК, ХК

нарын хооронд байгуулсан

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ**

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ**

**ТУХАЙ ГЭРЭЭ**

(ЗАГВАР)

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ,  
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

**ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

1. ГЭРЭЭЛЭГЧ ТАЛУУД ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫН НӨХЦӨЛ, ЖУРМЫН ДАГУУ ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭГ БАЙГУУЛНА.
2. ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ЗАГВАРТ ЗААГААГҮЙ БУСАД АСУУДЛЫГ ГЭРЭЭЛЭГЧ ТАЛУУД МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭХ ҮҮСГҮҮРИЙН ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЭН ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОЖ ГЭРЭЭНД ТУСГАЖ БОЛНО.<sup>1</sup>
3. ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АЛИВАА ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ ГЭРЭЭЛЭГЧ ТАЛУУД БҮРЭН ХАРИУЦНА.

**ОРШИЛ.**

А. Энэхүү ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭ (цаашид “ГЭРЭЭ” гэх)-г

**НЭГ ТАЛААС:**

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ (ЦДҮС ТӨХК, цаашид “ХУДАЛДАН АВАГЧ” гэх) түүнийг төлөөлж \_\_\_\_\_/албан \_\_\_\_\_ тушаал/ \_\_\_\_\_ ажилтай, \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_

**НӨГӨӨ ТАЛААС:**

“\_\_\_\_\_” ХК/ХХК (цаашид “ХУДАЛДАГЧ” гэх) түүнийг төлөөлж \_\_\_\_\_/албан тушаал/ ажилтай, \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нарын хооронд 20 \_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ өдөр байгуулав.

Б. Энэхүү гэрээгээр худалдагч нь \_\_\_\_\_ аймаг/хот \_\_\_\_\_ сум/дүүргийн \_\_\_\_\_ баг/хорооны нутаг дэвсгэр, \_\_\_\_\_ газарт байрлах \_\_\_\_\_ МВт-ын суурилагдсан хүчин чадалтай \_\_\_\_\_ (Нарны, Салхины, Усны, Биомассын, Газрын гүний дулааны) сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн, энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу худалдан авагчид худалдах;

В. Худалдан авагч нь энэхүү гэрээний нөхцөлийн үндсэн дээр худалдагчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг худалдан авагчийн дамжуулах сүлжээнд холбох, худалдагчийн диспетчерийн зохицуулалтаар нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифаар худалдан авахаар; тус тус харилцан тохиролцов.

<sup>1</sup> Талуудын гэрээнд нэмэлтээр тусгасан зохицуулалт нь энэхүү гэрээний загвараар батлагдсан зохицуулалтын агуулгыг өөрчлөхгүй, түүнтэй зөрчилдөхгүй байна. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төрөл, хүчин чадал зэргээс хамааруулан хоосон орхигдсон нүдийг талууд харилцан тохиролцон бөглөнө

---

## А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

---

### 1. Нэр томьёо

1.1. Энэхүү гэрээний загварт тодорхойлсон нэр томьёог дор дурдсан шууд утгаар ойлгох ба гэрээний загварт дурдагдаагүй өөр бусад нэр томьёог талууд харилцан тохиролцон тусгаж болно.

**“Арилжааны цэг”** гэж Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн цахилгаан нийлүүлэлтийн хэмжээг тооцох зориулалт бүхий худалдан авагчийн өмчилж буй тооцооны тоолуур болон худалдагчийн өмчилж буй хяналтын тоолуур суурилуулсан худалдан авагчийн дэд станцыг;

**“Арилжааны үйл ажиллагаа эхлэх өдөр”** гэж Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг ашиглалтад оруулах туршилт амжилттай явагдаж, “Барилга, байгууламж ашиглалтад оруулах комисс” хүлээн авсан өдрийг;

**“Цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлт”** гэж Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цахилгаан эрчим хүчний стандарт, Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан цахилгаан эрчим хүчний чанарын шаардлага хангасан байдлыг;

**“Цахилгаан эрчим хүчний үнэ, тариф”** гэж Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон нэгж кВт.цаг цахилгаан эрчим хүчний үнийг;

**“Тоолуур, хэмжих хэрэгсэл”** гэж Худалдах, худалдан авах цахилгаан эрчим хүчийг хэмжих, хянахад ашиглаж байгаа хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг;

**“Диспетчерийн Үндэсний Төв” /ДҮТ/** гэж эрчим хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг;

**“Диспетчерийн зохицуулалт”** гэж Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.26 дах заалтад тордорхойлсныг;

**“Диспетчерийн шийдвэр”** гэж цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээний дагуу нэгдсэн сүлжээнд хүлээн авах зохицуулалт хийх хүрээнд ДҮТ-өөс худалдагч, худалдан авагчид өгсөн даалгаврыг;

**“Худалдан авагчийн эрсдэлийн тохиолдол”** гэж худалдан авагч гэрээний үүргээ биелүүлээгүй, түүний буруутай үйл ажиллагаанаас худалдагчид учирч болох алдагдалыг;

**“Худалдан авагчийн эрсдэлийн тохиолдлын нөлөөллийг арилгах”** гэж энэхүү гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу худалдагч, худалдан авагчид учирч болох эрсдэлийг бууруулах, түүнийг арилгах талаарх арга хэмжээг;

### 2. Тайлбар

2.1. Гэрээг тайлбарлах талаар гэрээлэгч талууд харилцан тохиролцох ба тайлбар нь олон салаа утгыг илэрхийлээгүй, гэрээг нэг мөр ойлгоход дэмжлэг болохуйц байна.

**3. Гэрээний хэл ба хэрэглэгдэх хууль**

- 3.1. Гэрээг Монгол хэл дээр байгуулна.
- 3.2. Гэрээлэгч талууд харилцан тохиролцсон бол гэрээг өөр бусад гадаад хэл дээр байгуулж болно.
- 3.3. Монгол болон гадаад хэл дээрх гэрээ хоорондоо зөрчилдвөл Монгол хэл дээрх гэрээг баримтлана.
- 3.4. Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд Монгол улсын хуулийг хэрэглэнэ.
- 3.5. Хууль тогтоомжийн өөрчлөлт нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.
- 3.6. Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.

**4. Гэрээний хугацаа**

- 4.1. Энэхүү Гэрээ нь, “Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр”-өөр хүчин төгөлдөр болж, энэхүү Гэрээнд заасан журмын дагуу цуцлагдахаас бусад тохиолдолд, Арилжааны үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш \_\_\_\_\_ жилийн туршид хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөнө.

---

**Б. ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

---

**5. Нийлүүлэх цахилгаан эрчим хүчний чадал**

- 5.1. Худалдагч нь энэхүү гэрээнд заасны дагуу \_\_\_\_МВт-ын суурилагдсан хүчин чадалтай \_\_\_\_\_(Нарны, Салхины, Усны, Биомассын, Газрын гүний дулааны) сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон эрчим хүчний барилга, байгууламж барих тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу барьж, ашиглалтад оруулна.

**6. Цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлт**

- 6.1. Худалдагчийн нийлүүлэх цахилгаан эрчим хүч нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цахилгаан эрчим хүчний стандарт, Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан чанарын шаардлага хангасан байна.
- 6.2. Цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлтийг хангах талаар талуудын хүлээх эрх, үүргийг гэрээлэгч талууд харилцан тохиролцон тогтооно.

**7. Нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ, чадал**

- 7.1. Худалдан авагч нь Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан чанарын шаардлага хангасан, диспетчерийн үндэсний төвөөс баталсан тухайн сар, жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу диспетчерийн зохицуулалтаар үйлдвэрлэж нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг худалдан авч, энэ гэрээний 8.1-т заасан тарифын дагуу төлбөр төлөх үүрэгтэй.
- 7.2. Худалдан авагч нь цахилгаан станцын үйлдвэрлэлд Аварийн байдал, Төлөвлөгөөт зогсолт, Диспетчерийн зохицуулалт шийдвэрт зааснаас бусад тохиолдолд аливаа хязгаарлалт хийхгүй.

7.3. Арилжааны үйл ажиллагаа эхэлснээс хойш санхүүгийн жил бүрийг эхлэхээс \_\_\_\_\_-ээс доошгүй хоногийн өмнө худалдагч нь хүлээгдэж буй жилд сар бүр худалдахаар санал болгож буй нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ, чадлын талаар (санал болгож буй жилийн график) худалдан авагчид мэдэгдэнэ. Худалдагчаас ирүүлэх энэхүү саналд хүлээгдэж буй жилд мөрдөх төлөвлөгөөт зогсолтын хуваарийг багтаасан байна.

7.4. Энэ гэрээний 7.3-т заасан худалдагчийн санал болгосон санал болгож буй жилийн графикт худалдан авагч өөрчлөлт оруулах хүсэлтэй бол уг графикийг хүлээн авснаас хойш \_\_\_\_\_хоногийн дотор саналаа худалдагчид гаргаж өгнө.

7.5. Худалдагч нь энэ гэрээний 7.4-т заасан өөрчлөлт оруулах хүсэлтийг хүлээн авснаас хойш \_\_\_\_\_хоногийн дотор хүлээгдэж буй жилд мөрдөх хуваарийг дахин боловсруулан (Эцэслэн тохиролцсон жилийн график) худалдан авагчид хүргүүлнэ. Худалдан авагч нь худалдагчийн зүгээс гаргасан өөрчлөлт хийх үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан үзэж графикт өөрчлөлт оруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

## **8. Цахилгаан эрчим хүчний үнэ, тариф**

8.1. Худалдагч нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнэ, тарифаар худалдан авагчид цахилгаан эрчим хүчийг нийлүүлнэ.

8.2. Эрчим хүчний зохицуулах хорооноос худалдагчийн нийлүүлэх цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг баталсан тогтоол нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

## **9. Цахилгаан эрчим хүчний төлбөр, тооцооны нөхцөл**

9.1. Арилжааны үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс эхлэн худалдан авагч нь энэ гэрээний 7.1 дэх заалтад заасан цахилгаан эрчим хүчийг худалдан авч, энэ гэрээний 8.1 дэх заалтад заасан тарифаар төлбөрийг гүйцэтгэнэ.

9.2. Худалдагч нь өмнөх сарын нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэлийг дараа сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор худалдан авагчид хүргүүлж, худалдан авагч нь \_\_\_\_\_-ны өдрийн дотор төлбөрийг бүрэн барагдуулна. Хэрэв төлбөр гүйцэтгэх өдөр нь ажлын өдөр биш бол түүнийг дараагийн ажлын өдөр гүйцэтгэнэ.

9.3. Сарын төлбөрийн нэхэмжлэлд тооцооллыг дэлгэрэнгүй хэлбэрээр үзүүлж, худалдан авагчаас шаардаж болох бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

9.4. Худалдан авагч нь энэхүү гэрээний дагуу худалдагчид төлбөл зохих төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.3% хүртэлх тэнцэх алдангийг төлнө.

9.5. Талууд хэмжилт эсхүл нэхэмжлэлийн бичилтээс шалтгаалан цахилгаан эрчим хүчний төлбөр, тооцоонд алдаа гарсан гэж үзвэл нөгөө талдаа алдаа гарсан гэдгийг мэдсэнээс хойш \_\_\_\_\_хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй ба дээрх алдаатай холбоотой асуудлыг харилцан тохиролцон шийдвэрлэнэ.

9.6. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр, түүний өмчлөлийн дэд станц, холболтын шугамтай холбоотой байгаль орчинд ээлтэй үйл

ажиллагааг дэмжих хөнгөлөлт, хөрөнгө оруулалт нь гагцхүү худалдагчийн өмч байна.

9.7. Худалдан авагчын дэд станцтай холбогдох байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих хөнгөлөлт, хөрөнгө оруулалт нь гагцхүү Худалдан авагчийн өмч байна.

9.8. Гэрээтэй холбоотой өөр бусад төлбөр, тооцоо, түүнийг төлөхтэй холбогдсон асуудлыг талууд харилцан тохиролцон шийдвэрлэнэ.

#### **10. Диспетчерийн зохицуулалт**

10.1. Талууд цахилгаан эрчим хүчний системийн найдвартай, тасралтгүй, тогтвортой ажиллагааг хангах, нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсгүүдийн технологийн горим, төлөвлөлт, цахилгаан эрчим хүчний импорт, экспорт, техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцсэн зохицуулалт хийх тухай Диспетчерийн үндэсний төвийн шийдвэрийг заавал биелүүлнэ.

10.2. Диспетчерийн үндэсний төв нь энэ гэрээний 7 дугаар зүйлд заасан худалдагчийн нийлүүлэх цахилгаан эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд хүлээн авах зохицуулалтыг хийх ба энэхүү гэрээ болон нэгдсэн сүлжээний дүрмийн дагуу Худалдагч болон Худалдан авагчтай “Диспетчерийн зохицуулалтын гурвалсан гэрээ”-г байгуулна.

10.3. Диспетчерийн үндэсний төв нь энэ гэрээний 7 дугаар зүйлд зааснаас илүү үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг хэрхэн зохицуулах асуудлыг худалдагч, худалдан авагч талуудтай харилцан тохиролцсон байна.

---

### **В. ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ**

---

#### **11. Цахилгаан эрчим хүчний тоолуур, хэмжих хэрэгсэл, байршил**

11.1. Худалдагч болон худалдан авагч нь арилжааны цэг, худалдагчийн эзэмшлийн дэд станцуудад тооцооны болон хяналтын тоолуурыг суурилуулна.

11.2. Тоолуур, хэмжих хэрэгсэл нь Монгол улсын хууль тогтоомж, стандарт, холбогдох дүрэм, журамд заасан техник ашиглалтын болон бусад шаардлагыг хангасан байна.

11.3. Талууд хэмжих хэрэгслийн шалгалт, туршилт, тохируулгыг Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль болон түүнд нийцүүлэн баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасны дагуу гүйцэтгэнэ.

#### **12. Хэмжих хэрэгслийн төрөл, загвар, дугаар**

12.1. Тоолуур, хэмжих хэрэгсэл нь дор дурдсан төрөлтэй байна.

А. Тооцооны тоолуур;

Б. Хяналтын тоолуур.

12.2. Тооцооны тоолуурын загвар, төрөл, дугаарыг гэрээлэгч талууд харилцан тохиролцон энэхүү гэрээнд хавсралтаар оруулах ба уг хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

#### **13. Хэмжих хэрэгслийн нарийвчлал, хэрэглэгдэх**

13.1. Хэмжих хэрэгслийн нарийвчлал, хэрэглэгдэх итгэлцүүр нь Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай Монгол улсын хууль болон хэмжих хэрэгслийн нарийвчлалын улсын стандартад нийцсэн байна.

---

## итгэлцүүр

13.2. Талууд тоолуур, хэмжих хэрэгслийн өмчлөл, засвар үйлчилгээ, хяналт, шалгалт, хэмжих хэрэгслийн алдаа, түүнээс үүдэн гарах хариуцлага зэрэг асуудлыг харилцан тохиролцоно.

---

## Г. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА, ТҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

---

### 14. Талуудын хүлээх үндсэн үүрэг

14.1. Худалдагч нь Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж ашиглалтад оруулах, Монгол улсын “Нэгдсэн сүлжээний дүрэм”-д заасан чанарын шаардлага хангасан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн худалдан авагчид нийлүүлэх, Худалдан авагч нь диспетчерийн зохицуулалтын дагуу нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг худалдан авч төлбөр төлөх үүрэгтэй.

14.2. Гэрээлэгч талууд энэ гэрээний 10 дахь заалтад заасны дагуу Диспетчерийн Үндэсний Төвийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.

14.3. Худалдагч, худалдан авагч нь Нэгдсэн сүлжээний дүрэм, зах зээлийн загвар, тогтолцооны хүрээнд үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй ба Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль болон эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

14.4. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авахтай холбогдсон бусад эрх, үүргийг гэрээлэгч талууд харилцан тохиролцон тогтоож болно.

### 15. Худалдан авагчийн эрсдлийн тохиолдол

15.1. “Худалдан авагчийн эрсдлийн тохиолдол” гэж энэхүү цахилгаан станцын үйлдвэрлэх болон худалдан авагчид энэ гэрээний 7.1, 7.2 дах заалтуудын хүрээнд нийлүүлэх боломжтой цахилгаан эрчим хүчийг хүлээж авах дэд станцын ажлыг Худалдан авагч нь гэрээнд заасан хугацааны дотор гүйцэтгэж чадаагүйг ойлгоно.

15.2. Худалдан авагчийн эрсдлийн тохиолдлоос шалтгаалан Худалдагчийн үүргийн гүйцэтгэл хойшлогдсон, зогссон, саатсан бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.

15.3. Худалдан авагчийн эрсдлийн тохиолдлоос үүсэх хохирлыг барагдуулах талаарх зохицуулалтыг талууд харилцан тохиролцон гэрээнд нэмж тусгана.

### 16. Давагдашгүй хүчин зүйл

16.1. Давагдашгүй хүчин зүйл гэж талуудын урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан ба өөрийн бүх боломжоор түүнийг даван туулах, эсхүл зайлуулах буюу үр дагаврыг нь бууруулах боломжгүйгээс талууд энэхүү гэрээний болон гэрээний бүрдлийн үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн саатуулсан, зогсоосон нөхцөл байдлыг ойлгоно.

16.2. “Давагдашгүй хүчин зүйл”-д

(i) Тахал, халдварт өвчин буюу хорио цээр;



(ii) Монгол улсын гадна болж түүнд Монгол Улсын Засгийн Газар холбогдоогүй дайн, (зарлагдсан эсхүл зарлагдаагүйгээс үл хамааран) түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гадны халдлага; бүслэлт, худалдааны хориг (түлш эсхүл бусад материалыг бүрэн эсхүл хэсэгчилсэн хязгаарлалтыг оролцуулан), хувьсгал, бослого, хуйвалдаан, үймээн, терроризм; улс төрийн зорилго бүхий хорлон сүйтгэх болон барьцаалах ажиллагаа;

(iii) Дэлбэрэлт болон гал түймэр;

(iv) Үер, газар хөдлөлт, хөрсний гулсалт, аянга, хүчтэй шуурга, ган гачиг, цочир хүйтрэлт гэх мэт байгалийн гамшиг, эсхүл цаг агаарын бусад гэнэтийн ноцтой үзэгдэл, нөхцөл байдал;

(v) Энэхүү гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд саад болсон буюу түүнийг тасалдуулсан навигац, нисэх онгоц, усан онгоц, галт тэрэгний осол эсхүл бусад осол, сүйрэл;

(vi) Машин, тоног төхөөрөмж, үйлдвэр болон бусад аливаа байгууламжийн сүйрэл эсхүл тээвэрлэлт, харилцаа холбоо, эрчим хүчний урт хугацааны тасалдал;

(vii) Дээр дурдсан давагдашгүй хүчин зүйлийн тохиолдлуудтай ижил төстэй аливаа үйл явдал, нөхцөл байдлууд.

16.3. Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан аль нэг талын үүргийн гүйцэтгэл хойшлогдсон, зогссон, саатсан бол уг талыг гэрээний үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.

16.4. Талууд давагдашгүй хүчин зүйлтэй холбогдуулан хариуцлагаас чөлөөлөгдөхийг шаардах эрхтэй.

16.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадаагүй тал нь энэ тухайгаа уг давагдашгүй хүчин зүйл бий болсноос хойш эсхүл бий болсныг мэдэх ёстой байснаас хойш долоо хоногийн дотор нөгөө талдаа албан бичиг, телефакс, цахим шуудан, утас зэрэг боломжит хэлбэрээр яаралтай мэдээлэнэ.

16.6. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг талын үүргийн гүйцэтгэл хойшлогдсон буюу түүнд саад учирсан тохиолдолд тэрхүү тал нь гэрээний үүргийн биелэлтэд нөлөөлж буй уг нөлөөллийг багасгах талаар боломжит бүх арга хэмжээг авна.

16.7. Талууд давагдашгүй хүчин зүйл дуусгавар болсны дараа боломжит богино хугацаанд энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлээ урьдын адил хэвийн үргэлжлүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

16.8. Давагдашгүй хүчний зүйлийн улмаас хариуцлагаас чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг талууд харилцан тохиролцон нэмж тусгаж болно.

## **17. Гэрээг цуцлах**

17.1. Талууд дор дурдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй:

А. Талуудад олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан буюу олгосон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаагүй, нөхцөл шаардлагыг биелүүлээгүй болон өөр бусад нөхцөл байдлын улмаас

тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Б. Талуудын хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан.

В.Талууд энэхүү гэрээний 14.1-д заасан үндсэн үүргээ удаа дараа ноцтой зөрчсөн ба цаашид үүргээ биелүүлэх боломжгүй нь тогтоодсон

17.2. Гэрээг цуцлах өөр бусад үндэслэлийг талууд харилцан тохиролцон тогтоож болно.

**18. Гэрээ  
цуцалснаас үүсэх  
үр дагавар,  
хариуцлага**

18.1. Гэрээ цуцалснаас үүсэх үр, дагавар, гэрээний үүрэгтэй холбоотой аливаа хариуцлагын арга хэмжээг гэрээлэгч талууд харилцан тохиролцон тогтооно.

18.2. Талуудын хариуцлага нь Монгол Улсын Иргэний хууль болон бусад хуулийн зарчим, үзэл баримтлалд нийцсэн байх ба аль нэг талын эрх ашгийг хэт дордуулсан зохицуулалтыг нөгөө талдаа тулгахыг хориглоно.

**19. Маргаан  
шийдвэрлэх**

19.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөн шийдвэрлэх ба маргаан бий болсноос хойш 30 хоногийн дотор тохиролцоонд хүрч чадахгүй бол Эрчим хүчний зохицуулах хороонд хандаж зуучлалын замаар шийдвэрлүүлж болно.

19.2. Зуучлалын ажиллагаатай холбоотой зайлшгүй гарах зардлыг талууд тэнцүү хуваан хариуцана.

19.3. Зуучлалын замаар шийдвэрлэсэн шийдвэрийг талууд эвлэрэлийн гэрээгээр баталгаажуулж болно.

19.4. Гэрээлэгч талууд маргаантай асуудлыг зуучлалын замаар шийдвэрлэж чадаагүй бол гэрээтэй холбоотой аливаа маргааныг Монгол улсын шүүх, арбитр болон Олон улсын Арбитаар шийдвэрлүүлж болох бөгөөд энэ талаар харилцан тохиролцоно.

19.5. Хэрэв талууд маргаан шийдвэрлүүлэх шүүхийг сонгох талаар саналын зөрүүтэй бол Олон улсын арбитраар /Сингапур улсад/ шийдвэрлүүлэх нь давуу эрхтэй байна.

**20. Нэмэлт,  
өөрчлөлт**

20.1. Талууд ЭХЗХ-ноос баталсан гэрээний загварт заасан зохицуулалтыг өөрчлөх, түүнтэй зөрчилдөхөөс бусад асуудлаар гэрээнд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг баталгаажуулж, Эрчим Хүчний Зохицуулах Хороонд мэдэгдэнэ.

20.2. Талууд ЭХЗХ-ноос баталсан гэрээний загварт туссан зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд энэ талаар албан бичгээр хүсэлт тавих бөгөөд уг асуудлыг Эрчим хүчний зохицуулах Хорооны хурлаар шийдвэрлэнэ.